

**Барилга ХК-ийн санхүүгийн үйл ажиллагааны
талаархи мэдээлэл**

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

2016.04.09

Миний бие нь Мөнхцоож тус компанд 2013 оны 2-р сарын 18-нд ажилд орж тус компанид 3 дахь жилдээ ажиллаж байна.

Та бүхэнд 2015 оны санхүүгийн үйл ажиллагааг дараах байдалтайгаар товч танилцуулж байна. Балансын үлдэгдэл, орлогын тайланг дэлгэрэнгүйгээр өмнөх онтой харицуулсан байдалтайгаар өгсөн байна.

2015 онд борлуулалтын орлого 4,286,548.1 мянган төгрөг байгаагаас Оюу толгой төсөлөөс 170,181.1 мян төгрөг, МУИС-ын и-номын сангийн барилгын ажлаас 3 681 537 мян төгрөг, оффис түрээсээс 270,775 мян төгрөг, гараж түрээсээс 117,255.3 мян төгрөг бусад орлогоос 46,798.7 мян төгрөгийн орлоготой ажилласан.

Тайлант хугацаанд 2,480,043.7 мян төгрөгийн борлуулалтын өртөгтэй, үйл ажиллагааны 973,678.5 мян төгрөгний зардалтай, нийт 777,598.6 мян төгрөгийн ашиг , Цэвэр ашиг 709,9 сая төгрөг байлаа.

2015 онд Харья татварын хэлтэст ААНОАТ-67,685 мян, НӨАТ-345,892.3 мян, ХХОАТ-71,517.7 мян, ҮХХАТ-44,142.4 мян Газрын төлбөр 2,503.3 мян, АТӨЯХАТ –1,719 мян, НДШимтгэлд-187,644.1 нийт Улсын төсөвт 721 103.7 мян төг төлсөн байна. Сард дунджаар 59,4 сая төгрөг Улсын төсөвт шилжүүлдэг.

2014 онд “Дөлгөөн Хайрхан Уул Аудит” ХХК 3 жилийн гэрээ байгуулж өгсөн заавар зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажилсан байгаа. Тухайлбал Биет бус хөрөнгө/ санхүүгийн програм/ дээр элэгдэл байгуулсан, эзэнгүй өглөг борлуулалт болгон ил тодын хуулийн дагуу баланс дээрээс цэвэрлэсэн байна.

Энэ жил тус аудитын компаньтай үргэлжлүүлэн ажиллах болно.

Тус компани нь УБ оффис, ОТ талбайн ажилчид гэсэн 100 гаран хүний орон тоотойгоор 2015 онд ажиллалаа. Мөн НДШ болон ХХОАТ-ын тайланг улирал болгон харьяагдах татварт гарган давхардсан тоогоор 200 ажилчдын цалинг шивж тайлагнасан.

Мөн 2015 онд нийт 1 157,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнээс

Газар 790 сая, Ланд-200 145,6 сая төг, Хино рэнжир 18,6 сая төг, тавилга 3,3 сая төг

Ил тодын хуулийн хүрээнд

НӨАТ 198,7 сая төгрөгийн борлуулалтаас 19,8 сая төгрөгийн нөхөн татвар

ААНОАТ 285,1 сая төгрөгийн борлуулалтаас 28,5 сая төгрөгийн нөхөн татвар

ХХОАТ 187 сая төгрөгөөс 18,7 сая төгрөгийн нөхөн татвар

Гаалиар орж ирсэн бараанаас гаалийн татвар 14,3 сая төгрөг, НӨАТ-29,9 сая төгрөгийн нөхөн татвар нийт 111,2 сая төгрөгийн нөхөн татварыг ил болгож тайлагналаа.

Балансын үзүүлэлтээс 7 тэрбум-н хөрөнгө оруулалтаас 3 тэрбумын эзэнгүй өглөгийг цэвэрлэж, 4 тэрбумыг мөнгөн хөрөнгийг ил тод болгож үнэн зөвөөр тайлагналаа.

Мөн УТОХГазраас 2014 алдагдал баталгаажуулах зорилгоор шалгалт оруулж ААНОАТ-ын тайлангаар гарсан 188,9 төгрөгийн алдагдалын 106,1 сая төгрөгийн алдагдалыг баталгаажуулж 2015 онд төлөх ААНОАТ-н дүнг 10,6 сая төгрөгөөр бууруулж чадсан болно.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа

Энэ жилийн алдагдалтай гарсан шалтгааныг орлого, зардалд шинжилгээ хийж доорхи байдалтай тайлбарлаж байна.

1. 2014 оны замд яваа борлуулалт 169,838.1 мянган төгрөгийн борлуулалт 2015 оны эхээр орж тухайн оны борлуулалт болсон байгаа.
2. Албан томилолтын зардалыг өмнөх оныхтой харицуулхад 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа үүнд АНУ-д ИТАжилчид амарсан амралт 82,908 мянган төгрөг гарсан байна.
3. Ажилчдын сул зогсолтод нийт 21,827.5 мянган төгрөг НДШ Байгууллагад төлсөн
4. 2014 онд байгууллагын гадна пассатны засварын ажилд бараа материалын 57,231.1 мянган төгрөг, цалинд 34,708.4 мян төгрөг гадна хаяг 892 мян төгрөг нийт 92,831.5 мянган төгрөг зарцуулсан.
5. 2014 онд тендерийн ажилд суусан ажилчдын цалин 5,562 мянган төгрөг зарцуулсан
6. Оюу толгой төсөл амжилттай дуусагсан ИТА 36,512 мянган төгрөг ажилчидад 32,857.3 мян төгрөг шагнал урамшуулал олгож нийт 69,369.3 төгрөгийн зардал гаргасан
7. Элэгдэж дууссан машин тоног төхөөрөмж, худалдсан тээврийн хэрэгсэл, огт байхгүй элэгдэл нь дууссан тавилга эд хогшилыг данснаас хассаны гарз 41,263.4 сая төгрөг зардал
8. Тус зардалууд 2014 оны ашиг алдагдалд нөлөөлж үйл ажиллагаатай шууд бус холбоотой 313,761.7 мянган төгрөгийн зардалын хэтрэлт нөлөөлсөн байна.
9. Мөн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 34 хувийн өсөлттэй байна. Үүнд
 - 2013 оны зардал болох СС кемпийн гал тогооны агааржуулалтын тоног төхөөрөмж яндан хоолой нийлүүлэх Явуу импексийн 92,570 мян төгрөгийн зардал,
 - Даланзадгадийн ажилд ажилчдын хоол хүнсэнд 44,574 мянган төгрөг
 - Гадна пассатны 30,844 мян төгрөгийн зардал
 - Краны сургалтын 2,900 мян төгрөгийн зардал
 - Телехандрийн засвар үйлчилгээнд 4,103 мян төгрөгийн зардалНийт өмнөх оны 92,570 мянган төгрөгийн зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал 51,577 мянган төгрөг, оффисын засвар үйлчилгээний зардалтайн холбоотой 30 844 мян төгрөг ББӨртөгийг 174 991 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
10. 2014 онд нийт 198,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гарсан. Байгууллагын гадна засварт 92,8 үндсэн хөрөнгөнд 106,1 сая төгрөг
 - Үүнд Ланд-200 авто машин 93 сая, тавилга эд хогшилд 7,2 сая, машин механизм 6 сая (зуурмагийн машин) төгрөг байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярллаа